*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХАМРАЛТ, ОРЛОГЫН ХЭЛТСИЙН ӨР АВЛАГА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЧОГСОМЖАВЫН БААТАРЖАВЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин(биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах. | | | | | | | |
| 1.1 | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байх. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. “Нээлттэй мэдээллийн сар” аяны хүрээнд Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газраас зохион байгуулсан сургалтанд шимтгэл төлөгч 5 аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодогчийг, “Ажил олгогчийн зөвлөгөөн”-д 20 аж ахуй нэгж байгууллагуудын нягтлан бодогчийг хамруулан “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн шинээр нэмэгдсэн онцлог болон өөрчлөгдсөн | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зүйл заалтуудын сургалтанд хамруулсан байна. Мөн өдөр тутамд өөрийн хариуцсан аж ахуй нэгж байгууллагуудын нягтлан бодогч, захирал, даатгуулагч болон мэдээлэл зөвөлгөө авахаар хандсан хүмүүст заавар зөвөлгөө чиглэлийг хүргэн ажилласан байна. | | |
| 1.2 | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо | 2023 онд нийт 9 ажил олгогч, 13 хүнийг албан журмын даатгалд хамруулав. | 2024 онд нийт 35 ажил олгогч, 680 даатгуулагчийг албан журмын даатгалд хамруулах. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/61 тушаалаар салбарын хэмжээнд 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарласантай холбоотойгоор, Нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомж, түүний ач холбогдлыг сурталчилах ажлыг шат дараатай зохион байгуулж ажиллалаа. Үүнд:<br>➢ Тус хэлтсийн үүсгэсэн Баянгол НДХ-ААН фэйсбүүк группт нэгдсэн 3 мянган нягтлан бодогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчилан мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь хүргэн ажилласан.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар 93 ажил олгогчийн 1012 албан журмын даатгуулагчаар нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлсэн. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 1.3 | БГД-н Татварын | Татварын | Төлөгч аж ахуйн | Албан бичиг төлөвлөн | БГД-н татварын хэлтэсрүү татвар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлтсээс ирүүлсэн судалгаан дээр үндэслэн тус хэлтэст хамрагдаагүй ажил олгогчтой утсаар холбогдох хамруулах | хэлтсээс ирүүлсэн судалгааг үндэслэн өөрт хувиарлагдсан ажил олгогчдыг албан журмын даатгалд хамруулах | нэгж байгууллагын судалгааг авахаар 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 506 тоот албан тоот хүргүүлсэн. | холбогдох байгууллагад хүргүүлэх | төлөгч аж ахуйн нэгж байгууллагын судалгааг авахаар Газрын даргын 1296 тоот, 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 1688 тоот тус тус албан бичгийг хүргүүлсэн боловч албан тоотын хариу ирүүлээгүй болно. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 1.4 | Арга хэмжээ 1.4.<br><br>БГД-н 34 хороо, БГД-т үйл ажиллагаа явуулдаг томоохон үйлчилгээний байгууллагуудаас ирүүлсэн судалгааг үндэслэн өөрт хувиарлагдсан ажил олгогчдыг албан журмын даатгалд хамруулах | Өөрт хувиарлагдсан судалгааг үндэслэн 10-иас илүүгүй хувийг албан журмын нийгмийн даатгалд хамруулна | Хороодын Засаг дарга нарт хороо тус бүрт бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын судалгааг авахаар 2023 оны 04 сарын 20-ний өдрийн 507 тоот албан тоот хүргүүлсэн. | Албан бичиг төлөвлөн холбогдох байгууллагад хүргүүлэх. | Баянгол дүүргийн засаг даргын төрийн захиргаа удирдлагын хэлтэсрүү тус хороонд бүртгэлтэй ажил олгогчдын судалгааг авахаар Газрын даргын 1295 тоот албан тоотыг хүргүүлсэнээр. 2024 оны хагас жилийн байдлаар 93 ажил олгогчийн 1012 албан журмын даатгуулагчаар нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлсэн үзүүлэлттэй байна. | 2024.01.02<br>2024.12.31 | |

| |
|---|
| **Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** |
| Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх. | Батлагдсан 66,928,863,10 мянган төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 14,278,847.27 мянган төгрөгөөр буюу 98,82 хувиар биелүүлсэн. | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг батлагдсан 15.3 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байх. | 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 85,182,642.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 80,651,790,3 мянган төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 94,7 хувиар биелүүлэн ажилласан байна. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 2.2 | ЭМДЕГ-аас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх. | ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна | ЭМДЕГ баталсан ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлсэн. | ЭМД-ын сангийн орлогын хагас жилийн төлөвлөгөө 100 хувь биелсэн байна. | ЭМДЕГ баталсан ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлсэн. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 2.3 | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг | Ажил олгогчоос төлөх шимтгэлий | 2024 онд оны эхний авлага 4,9 тэрбум төгрөг. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. | 2024.01.02 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх. | н авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна | | авлага оны эхнээс 747 сая төгрөгөөр бууруулан ажиллах. | ➢ 1,625,836.5 мянган төгрөгийн өртэй 46 ажил олгогч байгууллагад улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж 9 ажил олгогчийн 375,461.4 мянган төгрөгийг барагдуулсан.<br>➢ 3,820,786.4 мянган төгрөгийн өртэй 357 ажил олгогчийн харилцах дансны зарлагын гүйлгээг хааж 153 ажил олгогчийн 1,239,200.2 мянган төгрөгийг,<br>➢ 1,113,005.58 мянган төгрөгийн өртэй 17 ажил олгогчтой нийгмийн даатгалын авлага бууруулах гэрээ байгуулж 10 ажил олгогчийн 264,798.1 мянган төгрөгийг барагдуулсан<br>➢ 2024 оны сүүлээр 598,912.03 мянган төгрөгийн өртэй 4 ажил олгогчийг нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн.<br>Дээрх ажлуудыг шат дараатай зохион байгуулж ажилсанаар 172 ажил олгогчийн 1,879,459.7 мянган төгрөгийн өр авлагыг барагдуулсан. | 2024.12.31 | |
| 2.4 | Төсвийн байгууллагуудыг шимтгэлийн өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах | Өр, авлага үүсгэхгүй байх | 2023 оны жилийн эцсийн байдлаар төсөвт байгууллагын өргүй гарсан байна. | Өр, авлага үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах | Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан өгдөг 11 төсөвт байгууллага байдаг.<br><br>Тус төсөвт байгууллагууд нь 2024 оны жилийн эцсийн байдлаа өр авлагагүй гарах талаар анхаарч Баянгол дүүргийн Засаг даргын | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран ажилласан. | | |
| 2.5 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжсэн шимтгэлийн авлагыг барагдуулах. | Барагдуулсан дүнгээр | Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчнартай уулзалт хийж тооцоо нийлэх. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд өгсөн өртэй байгууллагуудын өр буурсан байх. | 470,658,014.42 төгрөгийн өртэй 1 ажил олгогчийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжүүлсэн болно. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 2.6 | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | 892 ажил олгогч байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг 3-НД-7, 3-НД-8 үнэн зөв хүлээн авч баталгаажуулсан байна. | Тайланг 3-НД-7, 3-НД-8 маягтаар хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан байх. | Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хамтарсан "Маягт, журам батлах тухай" 246/А/245 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягт /3-НД, Б-НД/"-ыг мөн тушаалын 2-р дугаар хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх журам"-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг маягтын дагуу баталгаажуулж байна.<br>Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр 784 аж ахуйн нэгж байгууллага бүртгүүлж нийгмийн даатгалын санд шимтгэл төлж байна.<br>Эдгээр аж ахуйн нэгж байгууллагын шимтгэл төлөлтийн тооцоог батлагдсан маягтын хагас жил бүр | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаажуулан ажилласан. | | |
| **Зорилт 3. Хуулиар нийтлэг олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | |
| 3.1 | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах | Аж ахуйн нэгж байгууллагын 6 албан бичиг, иргэний 2 өргөдөлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл гомдлыг 100% шийдвэрлэх | https://erp.ulaanbaatar.mn программаар ирсэн аж ахуйн нэгж байгууллагын 92 албан бичиг, регистрийн дугаар засуулах 3 иргэний өргөдөлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 3.2 | Хэлтсийн үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийг хуулийн хугацаанд архивт шилжүүлэх | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан баримтын тоо | 2023 онд нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан өгсөн 57 боть баримт бичгийг архивт хүлээлгэн өгсөн | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан баримт бичгийг архивт хүлээлгэн өгсөн байх | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу 2023 онд нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан өгсөн аж ахуйн нэгж байгууллагын 57 боть баримт бичгийг архивт хүлээлгэн өгсөн байна. | 2024.01.02<br>2024.06.30 | |
| 3.3 | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй тогтоол, тушаал шийдвэр, үүрэг | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, тогтоол шийдвэр болон арга хэмжээ, ажил | Авлигын эсрэг хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн байна. | үйлчилгээний хэрэгжилтийг жигд хангах биелүүлэх. | сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг цаг тухай бүрт нь хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| 3.4 | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | Сургалтанд хамрагдсан байх | Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаа, зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа, авилга ашиг сонирхлын зөрчил зэрэг нэн шаардлагатай чиглэлийн сургалтанд хамрагдсан байна. | Авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах | Авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.12.31 | |

**Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт**

"Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад | Нийгмийн даатгалын | БГД-н 1-34 хороодод нээлттэй хаалганы | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан | Ажил олгогч, иргэд, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач | 2024.01.02 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах; | хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан байх | өдөрлөгийг зохион байгуулж, 2 байгууллагын 160 гаруй даатгуулагчдад нийгмийн даатгалын даатгалын тухай хуулийн шинэчлэлт, тэтгэвэр, тэтгэмжийн талаарх сургалтыг зохион байгуулсан. | бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн сургалтад хамрагдах ажил олгогчдын судалгааг гаргах | холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр зохион байгуулах нээлттэй хаалганы өдөрлөгийн хөтөлбөр, ажлын төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулан хэрэгжүүлж ажилласан байна.<br><br>➢ 2024 оны 06 дугаар сарын 05-07 хооронд Баянгол дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг томоохон худалдааны төв (Номин их дэлгүүр, E-mart худалдааны төв, Хархорин зах)-д нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын шинэчлэсэн хууль, тэтгэвэр, тэтгэмж, сайн дурын даатгалын талаарх зөвлөгөөг өгч ажиллаа.<br><br>Тус өдөрлөгт нийтдээ 400 гаруй иргэд даатгуулагчид хамрагдсан байна. Мөн “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн ач холбогдлыг ажил олгогч, даатгуулагч, иргэдэд сурталчлах, мэдээлэл өгөх, зөвлөн туслах үйлчилгээг идэвхжүүлэх зорилгоор 9 дүгээр сарыг “Нээлттэй мэдээллийн сар” болгон зарласан. | 2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Нээлттэй мэдээллийн сар” аяны хүрээнд Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газар нь “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулах төлөвлөгөө гарган 09 дүгээр сарын 20-ний өдөр 2 баг болон 10:00 цагаас 16:00 цагийн хооронд Энэбишийн өргөн чөлөө Байгаль эх цоцголбор, Хархорин худалдааны задгай талбай дээр зохион байгуулан ажилласан. Нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн талаарх 450 гаруй тараах материалыг иргэд даатгуулагч нарт тараан таниулсан. | | |
| 4.2 | Ажил олгогч байгууллагын нягтлан бодогч нарт танхимын сургалтыг зохион байгуулах | Сургалт зохион байгуулсан ажил олгогчийн тоо | Сургалт хөгжлийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 5 ажил олгогчдын нягтлан бодогч, хүний нөөцийн ажилнуудыг танхимын сургалтанд хамрууллаа. | Сургалтанд хамрагдах ажил олгогчдын судалгааг гаргах | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд дэвшүүлсэн Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх, мөн шинээр нэвтрүүлсэн SICOS программыг нэвтрүүлэхтэй холбоотой батлагдсан дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлалын талаархи сургалтыг 2024 оны 4 дүгээр сарын 19-ны өдөр Номин хайпермаркет дэлгүүрийн хурлын танхимд “Номин” ХХК-ийн салбар байгууллагуудын 50 гаруй нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтэнүүдийг сургалтанд хамрууллаа. Мөн 2024 оны 4 дүгээр | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сарын 29-ний өдөр ШУТИС-Механик, тээврийн сургуулийн лекцийн танхимд тээврийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын 55 нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтэнүүдэд танхимын сургалтыг зохион байуулсан.<br><br>"Ажил олгогчдын зөвөлгөөнийг ЯРИЛЦЛАГА-ХЭЛЭЛЦҮҮЛЭГ" хэлбэрээр зохион байгууллаа.<br><br>2024 оныг Хамрагдалтыг нэмэгдүүлэх жил болгон зарласантай уялдуулан тус газраас Ажил олгогчдын зөвлөгөөнийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн 14-17 цагийн хооронд "Royal house hotel"-д арга хэмжээг зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд 200 гаруй ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтнууд оролцлоо.<br>2024 оноос хэрэгжиж байгаа хэрэгжиж байгаа Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга, өөрчлөлтүүдийн талаар танилцуулсаны дараа тус зөвлөгөөндх үрэлцэн ирсэн ажил олгогч, байгууллагын дунд нээлттэй асуулт, хариулт, хэлэлцүүлэгийн арга хэмжээ зохион байгуулсан. Зөвлөгөөний үеэр Монголын үндэсний олон нийтийн радио | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | телевиз, Улаанбаатар телевиз ирж зөвлөгөөний үйл явц, арга хэмжээний талаар шууд нэвтрүүлэг хийж, ажил олгогчдын төлөөлөөс ярилцлага авч ажилласан. | | |
| 4.3 | Ажил олгогчдыг төлж буй үйлдвэрлэлийн ослын хувь хэмжээ тус бүрээр ангилан сургалт зохион байгуулах | Сургалтыг 3-с багагүй удаа зохион байгуулах | Эрх бүхий байгууллагын сонгон шалгаруулалтыг зарлан сургалтыг зохион байгуулан ажилласан байна. | Сургалтанд хамрагдах ажил олгогчдын судалгааг гаргах | Ажил олгогчдыг төлж буй үйлдвэрлэлийн ослын сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br><br>Уг сургалтыг зохион байгуулах эрх бүхий байгууллагын сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд түгээсэн байна. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 4.4 | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах; | Сурталчилгаа зохион байгуулсан тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, түүний ач холбогдлыг сурталчилах ажлыг шат дараатай зохион байгуулж ажилласан байна. | Шинэ ажил олгогчдыг хамруулах 1 эх постерын бэлтгэл санаачилан түгээсэн байх | Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлтүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчилах олон ажлыг зохион байгуулсан.<br>1. Нийгмийн даатгалын хууль тогтоомж, шинэчлэл, үзүүлж буй үйлчилгээ, газрын үйл ажиллагаа, цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг газрын албан ёсны фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан 55 удаагийн постер мэдээг нийтлэн түгээж хүргэсэн.<br>2.Хөлмөр нийгмийн хамгааллын яам, Авилгатай тэмцэх газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бусад газраас нийгмийн даатгалын хууль тогтоомжтой холбоотой ирүүлсэн мэдээ, мэдээллийг тухай бүрт нь газрын пэйж хуудас болон байцаагч, ажилтнуудын фэйсбүүкээр дамжуулан олон нийтэд түгээн сурталчилан ажилласан. | | |
| “Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ: | | | | | | | |
| 4.5 | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн хувь | Албан журмын даатгал төлдөг 10,969 даатгуулагчийн мэдээлэл улсын бүртгэлийн мэдээлэлтэй 100 хувь нийцсэн байна. | Ажил олгогчийн үндсэн мэдээлэл буюу ЭЗҮАСА, өмчийн болон хариуцлагын хэлбэр, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | 784 ажил олгогчийн үндсэн мэдээлэл Сикос программд үнэн зөв бүртгэгдэж 100% нийцсэн болно. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 4.6 | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх | Мэдээллийн үнэн зөв байдал | Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөгч 684 ажил олгогчийн 10,969 даатгуулагчийн үндсэн мэдээлэл, даатгуулагчий | Даатгуулагчийн үндсэн мэдээлэл төрлийг зөв хүлээн авсан байна.<br>Даатгуулагчийн улсын кодыг зөв хүлээн авсан байна.<br>Тухайн ажил олгогч дээр нэг | Албан журмын даатгал төлдөг 11,969 даатгуулагчийн мэдээлэл улсын бүртгэлийн мэдээлэлтэй 100 хувь нийцсэн болно. | 2024.01.02<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | н төрөл, улсын кодыг үнэн зөв хүлээн авсан байна. | сар дээр нэг даатгуулагчийг нэгээс илүүгүйгээр тайланд тусгуулсан байна. | | | |
| 4.7 | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | Мэдээллийн үнэн зөв байдал | 10,969 албан журмын даатгуулагч сайн дурын даатгалтай давхардаж бүртгэгдээгүй байна. | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй, НДШ тайланг үнэн зөв хүлээн авах | Албан журмын даатгал төлдөг даатгуулагчийн мэдээлэл улсын бүртгэлийн мэдээлэлтэй 100 хувь нийцүүлэн нийгмийн даатгалын тайланг хүлээн авч ажилласан. | 2024.01.02<br>2024.12.31 | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин(биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хүрээнд 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулахад бэлтгэгдсэн байх тул монгол бичгээр уншиж, бичиж сурах. | Монгол бичгээр уншиж, бичиж сурсан байх | НДЕГ-с зохион байгуулж буй монгол бичгийн анхан шатны сургалтанд хамрагдсан. | Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас хийсэн Монгол бичгийн дунд шатны цахим сургалтанд хамрагдан суралцсан. | 2024.01.00<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Газраас зохион байгуулсан сургалт, мэдээллийн цагт бүрэн хамрагдах. | Зохион байгуулсан сургалтанд бүрэн хамрагдах | АТГ-ын онлайн сургалтанд хамргадсан. | Шинээр батлагдсан хуулийн дагуу гарсан зөвлөмж, тушаал шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан ажиллах. | НДЕГ–аас болон Газрын зүгээс зохион байгуулсан цаг үеийн холбогдолтой танхимын болон цахим сургалтанд тухай бүрд хамрагдсан. | 2024.01.02<br>2024.12.31 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| ХАМРАЛТ, ОРЛОГО ХЭЛТСИЙН ӨР АВЛАГА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН | /Ч. БААТАРЖАВ/ …………………….. | 2024.12.11 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |